| | эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих; | 0 | | чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжин ажиллаж байгаа хэдий ч ковид 19 цар тахлын цаг үеийн байдлаас шалтгаалан хойшлогдож байна. ЗДТГ-н залуу ажилчидад Олон жил төрийн албанд ажилласан ахмад ажилтан, төрийн албан хаагчын ёс зүйн талаарх сургалт хийсэн. | |
| **2.5 Үндэсний бахархал, өв соёл** | | | | | |
| **Зорилго: Соёлын ажлын агуулга хэлбэр, төрөл зүйл, чанар хүртээмж, үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулж, материаллаг баазыг бэхжүүлнэ.** | | | | | |
| **Зорилт: 2.5.1 Үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулж, материаллаг баазыг нэмэгдүүлэх** | | | | Соёлын Яамны санхүүжилтээр 17869427 төгрөгний тайзны хөшиг,4563900 төгрөгний үндэсний хөгжим,68606467.39 төгрөгний дуу авианы техник,лед дэлгэц, компьютер,зургийн аппарат, 500.0 төгрөгний ном,хандиваар 1023000 төгрөгний ном, сумын ОНХС-ийн 20 сая төгрөгний гадаа талбай, "Ижий говь" төслөөс 2950.0 төгрөгний суурин компьютер нийт 97143367 төгрөргний хөрөнгө оруулалт хийгдсэн. | |
| 2.5.1.1. | Арга хэмжээ: Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанарыг сайжруулах,нэмэгдүүлэх/дуу авиа, гэрэлтүүлэг, дүрс бичлэг | | | ОНХС-аас 50 сая төгрөгний иж бүрэн тоног төхөөрөмж бүхий нүүдлийн соёлын төв, 3,5 сая төгрөгний дүрс бичлэгийн камер, хандив тусламжаар 580 мянган төгрөгний өнгөт принтер. 77143367.0 төгрөгний 32 төрлийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. | 90 |
| 2.5.1.2 | Урлагийн иж бүрэн хувцастай болох | | | Урлагийн иж бүрэн хувцасны 38.140.000 төгрөгний /62 хос,182ш/ “Дэгжин гоёл” төсөл боловсруулан Сумын засаг даргад хүргүүлсэн. 480000 төгрөгний өртөг бүхий Ардын бүжгийн 6 хос дээл авсан. | 90 |
| 2.5.1.3. | Хашаажуулж ,задгай талбай байгуулах | | | Үйлчилгээний осол аюулгүй, таатай орчин бүрдүүлж эрсдлээс хамгаалах зорилгоор “4Х буюу Хашаа-Хамгаалал-Хүүхэд-Хөгжил” төслийг бичиж ОНХС-аас 20 сая төгрөгөөр санхүүжигдэхээр дэмжигдсэн. 2022 | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | онд задгай талбай байгуулах ажлыг Өндөр буянт итгэлцэл нөхөрлөлтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Сумын ОНХ-ийн 20 сая төгррөгний санхүүжилтээр гадаа талбайтай болсоноор урдуур явах машины тоо эрс буурч мөн гадаа олон нийтийн ажил зохион байгуулах орчин бүрдсэн | |
| 2.5.1.4. | Орон нутаг судлах танхим байгуулах | | | Орон нутаг судлах танхим байгуулах үзмэр хорго хийх төсөл боловсруулалт судалгааны шатандаа явж байна. Хүндэтгэлийн өргөөг ОНСТ-ын зориулалтаар балансаас балансад шилжүүлэн өвсөн. Музейд шинээр үзмэр 10 бүртгэж авсан. | 70 |
| Зорилт 2.5.2. | Соёлын төвийг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх. | | | Судалгааны шатандаа байна. | |
| 2.5.2.1 | Арга хэмжээ:Соёлын төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, шаардлагатай боловсон хүчнийг үе шаттай сургах төлөвлөлт хийж мэргэжил мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | | Соёлын өвийн ажилтны орон тоог нэмэгдүүлж ажилтнуудаа Орон нутгийн соёлын салбарын хүний нөөцийн мэргэжил дээшлүүлэх 40 цаг (2.0 кредит)-ийн сургалт, 3-6 удаагийн чадавхжуулах сургалтад тус тус 100% хамруулсан. Нийт 5 сургалтад давхардсан тоогоор 21 ажилтан хамрагдсан.<br><br>1. Соёлын яамны санаачилгаар Соёлын сургуулийн зохион явуулсан цахим сургалтад 5<br><br>2. Сумын хэлний бодлогын зөвлөл , монгол хэлний багш нартай хамтран төрийн албан хаагчдын дунд Монгол бичгийн сургалт 6<br><br>3. Соёлын яамны захиалгаар Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан салбарын “Хүний нөөцийн мэргэжил дээшлүүлэх" сургалт 2 | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 4. "Соёл урлагийн салбарын хүний хөгжлийг дэмжих нь" сургалт 5.<br><br>5. Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ" цахим сургалт 5 | |
| 2.5.2.2. | Орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчнийг мэргэжлийн их, дээд сургуулиудад сум, байгууллагын гэрээгээр суралцуулан бэлтгэж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх | | | Дутагдалтай боловсон хүчин одоогоор байхгүй байна. | 90 |
| **Зорилт: 2.5.3 Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх** | | | | | |
| 3.5.3.1 | Арга хэмжээ: Морин хуур, уртын дууны сургагч багш нарыг бэлтгэн, сургалт явуулж, морин хуурын хамтлаг, уртын дууны чуулга байгуулан, дуу хуураа өвлүүлэн хөгжүүлэх. | | | Морин хуурын сургалтаар 8 хүүхдэд нийт 22 цагийн сургалт явуулж Монгол аялгуу,Үүлэн бор аялгуунуудыг, Уртын дууны сургалтаар 12 хүнд Энхмэндийн баяр Айзам уртын дууг сэргээн зааж Монголын цагаан сарын баяраар цахим мэндчилгээ бэлтгэн сумынхаа 4 группээр дамжуулан хүргэж 180 хүний хандалт авч, мөн Монголын Соёлын ажилтнуудын эрин холбооноос зарласан" Цагаан сарын мэндчилгээ" цахим арга хэмжээ, Аймгийн өвлөн уламжлагчдыг тодруулах Ардын урлагийн их наадамд гоцлол төрөлд морин хуур-1, уртын дуугаар-2 хамтлаг төрлөөр 10 хүнийг амжилттай бэлтгэж оролцууллаа. Морин хуурын дугуйлангаар 35 хүүхэд 2 насанд хүрэгч 60 цагийн дугуйлангаар мандал говийн магтаал, халх жонон, миний нутгийн бараа гэсэн 3 аялгууг зааж сургалаа. Уртын дуу 34 цагийн сургалтаар 10 хүүхэд 6 насанд хүрэгч 1 дууг тус тус зааж сургалаа.<br><br>• Зээ татах сургалт хамрагдсан хүүхдийн тоо 36<br><br>• Морины цол дуудах сургалт 14 | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.5.3.2 | Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээт хамгаалагчтай болгох | | | Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг 100% гэрээт хамгаалагчтай болгож гэрээг байгуулсан. ТСҮХД-т газар-26 Гэрээт хамгаалагчийн тоо-23 шинээр 2022 онд 4 ТСҮХД-т газар бүртгэж гэрээ байгуулан хамгаалуулсан. | 90 |
| 2.5.3.3 | Орон нутаг судлах танхимыг түшиглэн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх | | Сургалт-1, хамрагдсан хүүхдийн тоо-14 | Насан туршийн боловсролын багштай хамтран Соёлын өвийг сурталчлан таниулах зорилгоор сумын 4 групэд цахимаар 2 удаа, ЕБС-ийн 14 хүүхдэд орон нутаг судлах танхимаар мэдээлэл өглөө.Олон улсын музейн өдөрт Орон нутаг судлах танхимаас “Музей бидний төсөөллөөр” бүтээлийн уралдаан зохион байгуулж Цэцэрлэгийн Бэлтгэл, Ахлах насны хүүхдүүд “Миний хайртай амьтан” баримлын шавран бүтээлд 8 хүүхэд, 1-5-р ангийн сурагчид “Музей миний төсөөллөөр” гар зургийн уралдаанд 6 хүүхэд нийт 14 хүүхэд идэвхтэй оролцлоо.Угийн бичиг хэрхэн хөтлөх вэ? Сургалт ЕБС-ийн 8,9-р ангийн 43 сурагчдад явуулсан. Монгол өв соёлын Монголын баялаг 330 хөтөлбөрт нутгийн өв соёлын талаар нэвтрүүлгийг төсөл хэрэгжүүлэгчдийн хамтаар бэлтгэн телевизээр сурталчлан таниулах ажил хийгдэв. Нийт 7 сургалт зохион явууллаа. Үүнд:<br><br>• Хүмүүжил төлөвшилтэй Хулдын хүүхдүүд аяны хүрээнд Түүх соёлын дурсгалт газар болон ТСҮХД-т газартай танилцуулах тойрон аялалын сургалт<br><br>• Монгол аман уламжлал дайралцаа 1-5 анги сурагчдын сургалт.<br><br>• Уртын дуу<br><br>• Морин хуур<br><br>• Бий биелгээ | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | • Боржигин Зээ татах сургалт<br>• Морины цол дуудах сургалт | |
| 2.5.4.5 | Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлж урьд оноос нэмэгдүүлнэ. | | | 2020 онд 85 өрх буюу 11,5%"тай байсан бол 2021 онд 7- өрх шинээр хөтөлж 12,5% болж 1%-иар өссөн. Өмнөх онд 12,6% байсан бол 2022 онд шинээр 66 өрх хөтөлж нийт өрхийн 20,48% угийн бичгээ хөтлөөд байна. 12 сард болзолт уралдаан дүгнэхэд хөтөлсөн өрхийн тоо нэмэгдэх боломжтой. | 50 |
| 2.5.4.6 | Угийн бичгийн сургалтыг явуулж, үр дүнг тусгай болзол журмын дагуу дүгнэх | | | "Угийн бичигтэн өрх" шалгаруулах болзол журмын дагуу 12 сард шалгаруулж шинэ жилээр шагналыг гардуулна. "Угийн бичигтэн өрх" шалгаруулах болон "Угийн бичигтэн байгууллага" шалгаруулах Болзолт уралдаан зарласан. Хугацаа болоогүй 12 Сард дүгнэж шинэ жилээр шагнал гардуулна | 70 |
| **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | |
| 3.1 | Зорилго:Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын баазыг нэмэгдүүлнэ | Санхүү, төсвийн зохицуулалт | | Татварын үйлчилгээ бүрэн цахимжсан тул иргэдэд цахимаар үйлчлэхийг уриалж, зааварчилгаа өгч ажилладаг. Жилийн эцсээр 3 ААНэгж, 1 иргэн нэмэгдэж нийт 51 аж ахуйн нэгж бүртгэгдэж, татварын бааз нэмэгдсэн | 90 |
| 3.1.1 | Зорилт: Татварын тухай хууль болон цахим татварын бүх төрлийн үйлчилгээг иргэдэд сурталчилах | | | Иргэн, ААНэгжид тайлан тооцоо гаргах, татварын тухай ойлголт, хууль татварын шинэчлэл зэрэг үйлчилгээг цахимаар хүргэж байна. Сумын иргэдийн 60 хувь нь цахимаар мэдээллээ авч байна. | 90 |
| 3.1.1.1 | Арга хэмжээ:Татвар төлөгчдийн нэгдсэн арга хэмжээний өдөрлөгийг зохион | | | Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд татварын өдөрлөгийг цахимаар буюу фэйсбүүк-р дамжуулан тайлангийн зааварчилгаа, мэдээ | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байгуулж, иргэд, ААН,татвар төлөгчдийг хамруулж төрийн үйлчилгээг үзүүлэх | | | мэдээллийг цаг бүрд нь мэдээлж байна. Жишээ нь 2021 оны 01 сарын 01 нээс хэрэгжиж эхэлсэн малын тоо толгойн албан татварыг хураах малчин бүрийн тайланг гаргах зэрэг үйл ажиллагааг 2021 оны мал тооллогоор малчин өрх бүрд заавр ыг өгч танилцуулсан. Мэдээллийн цаг малчдын чуулга уулзалт, залуу малчдын уулзалт, БИНХ-аар татвар, малын тоо толгой татварын талаар тухай бүх мэдээлэл өгч, гарын авлага тарааж. Малчин өрх бүрд татварын ноогдолыг системээр нэхэмжлэх үүсгэж ажилласан. | |
| 3.1.1.2 | Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь биелүүлэх | | | Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2021 оны 11 сарын мэдээгээр Орон нутгийн төсвийн орлого 111% Сумын төвлөрсөн орлого 142.9% Татварын бус орлого 178.3% Аймгийн төвлөрсөн орлого 89.2% Улсын төвлөрсөн орлого 128.5% байна. | 90 |
| 3.1.2.1. | Арга хэмжээ: Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон цахим хуудсаар тухай бүр мэдээлэх | | | Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон цахим хуудсаар тухай бүр оруулж мэдээлж ажиллаж байна. 2022 онд 2 тендер зарлаж гэрэлтүүлэг, мэдээллийн 1 тендэр буцсан. Аврах байрны тендерт оролцогчийг шалгаруулан гэрээ байгуулсан. Тендерийг цахимаар зарлаж үр дүнг тухай бүр системд оруулж ил тод байдлыг ханган ажиллав. | 90 |
| 3.1.2.2. | Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах | | | Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны 4 гишүүн ажиллаж байна.Гишүүдийг бичиг хэргийн материалаар хангаж дэмжлэг урамшуулал үзүүлж байна.2021 онд ХАА-ны А3 сертификадын цахим сургалтанд хамрагдсан 5 хүн шалгалтанд тэнцсэн. 11 сард А3 сертификатын сургалтанд 8 хүн хамруулан сургаж 5 хүн тэнцүүлж нөөцөө нэмэгдүүлэв. Сургалтын төлбөрийн 100 хувь байгууллагаас гаргав. | 90 |
| **2 Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | |
| 3.2.1.Зорилт:Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2019 онд 647.5 сая төгрөг байгааг 2024 онд 2,648.0 сая төгрөгт хүргэнэ. | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.2.1.1 | Арга хэмжээ: Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ 2020 онд 2 байсныг 2024 онд 18 болгон нэмэгдүүлэх | | | Одоогоор Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ хийх Төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа. 2022 онд шинэчилсэн судалгаагаар 5 ашиглалтын, 9 хайгуулийн, 2 түгээмэл тархацтай хайгуулийн тусгай зөвшөөрөл байна. Эдгээр аж ахуйн нэгжтэй орон нутгийн хөгжлийг дэмжих гэрээ байгуулахаар гэрээний төслийг бэлтгэн ажиллаж байна. | 90 |
| 3.2.1.2 | Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэнэ. | | | Одоогоор Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй. | ХБ |
| 3.2.1.3 | Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, "Дундговь аймгийн хөгжлийг дэмжих сан" байгуулах | | | Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, "Дундговь аймгийн хөгжлийг дэмжих сан" байгуулах ажил хийгдэж байгаа. | 90 |
| 3.2.1.4 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах | | | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулагдсан. | 90 |
| **3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр** | | | | | |
| Зорилго: Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний төрлөөр орон нутгийн иргэдийн хэрэгцээний зохих хувийг хангаж, иргэдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана. | | | | | |
| 3.3.1. Зорилт:Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг жил бүр өсгөн нэмэгдүүлэх. | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.3.1.1. | Арга хэмжээ: Мал төхөөрөх, нядалгааны цэг байгуулах | | | 2021 онд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн чиглэлд мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, мал төхөөрөх нядалгааны цэг байгуулах иргэд, аж ахуй нэгжийн төслийг дэмжихээр баталсан. Мал төхөөрөх, нядалгааны цэг байгуулах ажил хийгдэж эхлээгүй байна. | 50 |
| 3.3.1.2 | Хүн амын өвөл, хавар, зуны хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлж махны хангамж, үнийн тогтвортой байдлыг хангах | | | 2021 оны эхэнд 259.478 толгой мал тоологдсон. Өвөл хаврын цаг зудын байдлаас 22.099 толгой мал хорогдож шинээр 10.825 толгой тол мал нэмэгдсэн.4632 толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. | 90 |
| 3.3.1.3 | Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоодын зах зээлд нийлүүлэх малчид, хоршоод, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах. | | | Говийн зэрэглээ төслийн хүрээнд тэмээчдийг ингэний сүү хоормог бэлтгэн зах зээлд нийлүүлэх орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор Олдох багийн малчдад цагаан идээ боловсруулах модон сав нийлүүлэх ажил хийгдэж эхлээд байна. Мөн Олдох багийн малчин Ц.Саадорж тэмээний ноосоор /ногт, бурантаг, ботогны уяа гм.../ орон нутгын онцлогийг харуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэглэгчдэд нийлүүлж байна. | 90 |
| 3.3.1.4. | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх малчин өрхийн тоог нэмэгдүүлэх | | | Засгийн газраас хэрэгжүүлж буй 10 их наяд цогц бодлогын хүрээнд малчдыг дэмжих арга хэмжээ хөнгөлөлттэй зээлэнд 60 малчин өрх , 560 сая төгрөгний зээлэнд хамрагдаж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх малчин өрхийн тоо нэмэгдсэн байна. | 70 |
| 3.3.1.5 | Ноос, арьс ширний анхан шатны боловсруулалт хийх, иргэдийн санал санаачилгыг дэмжих | | | Сумын ИТХ-аар Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн чиглэлд арьс ширний анхан шатны боловсруулалт хийх иргэдийн төслийг дэмжин ажиллах чиглэлд оруулан батлуулсан. | 50 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.3.1.6. | Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих | | | Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүдийг дэмжих 10 их наяд цогц бодолгын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөр бизнэс эрхлэгч 5 иргэн аж ахуйн нэгж 195 сая төгрөгний хөнгөлтэй зээл авж үйл ажиллагаагаа явуулж байна.ИТХ-аар 2021 онд 100 сая төгрөгийг үйлдвэр үйлчилгээ эрхлэх 5 чиглэлээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгохоор болсон. 2022 оны 12 сард ИТХ-ын шийдвэрээр байгуулсан хоршоо дэмжих сангийн хороог хуралдуулан зээл хүссэн 5 төслийг хэлэлцэн дэмжиж 79 сая төгрөгний зээл олгох шийдвэр гаргав. | 90 |
| **Зорилт: 3.3.2. Малын тоог чанарт шилжүүлж, орчин үеийн шинэлэг ололтыг нэвтрүүлэн малын генетик нөөцийн чанарыг нэмэгдүүлнэ** | | | | | |
| 3.3.2.1 | Арга хэмжээ: Олдохын хүрэн бор омгийн тэмээний тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлж бусад аймаг, сумдад сайжруулагчаар ашиглуулах | | | Олдохын Хүрэн бор омгийн тэмээг Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь аймгийн сумдуудад малчид зарж сайжруулагчаар ашиглаж байна. | 90 |
| 3.3.2.2 | Сумын хэмжээнд бог малын сайжруулагч хээлтүүлэгчийг ашиглаж, малын тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх | | | Хулд таван эрдэнэ ХХК мал үржүүлэг технологийн нэгжид Эрдэнэ далай сумын Цавчир багаас 20 өсвөр хээлтүүлэгч авчран ашиглаж байна | 90 |
| 3.3.2.3 | Жилд 5-аас доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж, үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах | | | Хулд сумын малчид шинээр үхэр сүргээ чанаржуулах сайжруулах зорилгоор өөрийн аймгийн нутгаас 5 бух сайжруулагчаар ашиглаж байна. | 90 |
| 3.3.2.4 | Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг эзэмшүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах | | | Олдохын Хүрэн бор омгийн 1000 тэмээг эзэмшүүлэн бүртгэлжүүлсэн. | 90 |
| **3.3.3. Зорилт: Бэлчээр ашиглагчдын хэсгийг чадавхижуулан дэмжих замаар бэлчээрийг зохистой ашиглаж нөхөн сэргээх** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.3.3.1 | Арга хэмжээ: Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Бэлчээр ашиглагчдын хэсгийг чадавхижуулан дэмжих замаар бэлчээрийг зохистой ашиглаж нөхөн сэргээх | | Багуудын хурлаар БАХ-ын ахлагч нар бэлчээр хамгаалах нөөц бэлчээрийн талаар хэлэцүүлсэн. Иргэд бэлчээр хаших хүсэл тавьсан уг саналыг дэмжиж ажиллана гэж удирдлагууд ярилцаж хэлэлцсэн. | 70 |
| 3.3.3.2 | Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах. | | | Сумын хэмжээнд судалгаагаар хортон мэрэгч,амьтан шавьжны тархац багатай тул урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагагүй байна. | 90 |
| 3.3.3.3 | Малын бэлчээрийн талбайд гүн өрмийн худаг гаргах, энгийн уурхайн худгуудыг засварлах | | | Орон нутгийн сангийн 4 сая төгрөгний хөрөнгөөр Улаан жирмийн энгийн уурхайн худгийг засаж янзлан хүлээлгэн өгсөн.Мөн орон нутгийн сангийн хөрөнгөөр гаргах 1 гүн өрмийн худгийг Бүлээн багийн нутагт гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл 50%, иргэд өөрсдийн хөрөнгөөр 50%, санхүүжилтээр Олдох баг Цагаан усанд 1 гүн өрмийн худаг гаргасан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 худгийн цооног Баг тус бүрт гаргасан. | 90 |
| 3.3.4 | Зорилт:Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлж вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | | | Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлж вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. 2021 онд тус суманд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын тоо толгойг шулхий мялзан өвчин гарсан учир 50 мянган мал болгон бууруулан ажиллах нөхцөлгүй байсан. | 90 |
| 3.3.4.1 | Арга хэмжээ:Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгох | | | Мал эмнэлгийн нэгдсэн систем бүрэн нэвтэрсэн. Малчид, мал бүхий иргэдэд мал эмнэлгийн гарал үүслийн 300 гэрчилгээ цахимаар олгосон. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.3.4.2 | Мал угаалгын суурин ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашаа барих | | | Хөрөнгийн асуудлаас болж шинээр хийгдсэн ажил байхгүй. Суурин 1 ванн, угаалгын хашаа 1 байгаа мөн явуулын 2 ванн байдаг. Угаалга ариутгалын үйлчилгээг тогтмол хийж байна. | 70 |
| 3.3.4.3 | Сумын хэмжээнд тарилгын вакцин хадгалах хөргүүр, мал эмнэлгийн аптек шинээр байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг ажил үйлчилгээ явуулахад шаардагдах нөхцөл бололцоогоор хангах | | | Эмийн сан 1 ажиллаж үйлчилгээг тогтмол явуулж байна. Хөргүүр суманд байхгүй. 2022 онд аймгийн хэмжээнд бүх суманд хийгдэхээр болсон | 50 |
| 3.3.4.4. | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тоог нэмэгдүүлж, малчин өрхийн мал сүрэгт үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | Суманд одоогоор мал эмнэлгийн үйл ажиллагааг 2 аж ахуйн нэгж малчдад үйлчилгээг нийт 200 гаруй мянган малд үзүүлж байна. | 70 |
| **3.4 Аялал жуулчлал** | | | | | |
| 3.4.1.Зорилт:Аялал жуулчлалын маршрутанд сумыг хамруулах ажлыг зохион байгуулж аялалын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн бизнесийг дэмжин хөгжүүлэх | | | | | |
| 3.4.1.1 | Арга хэмжээ: Төв зам дагуу үйлчилгээний газруудад эко ариун цэврийн байгууламж байгуулах, сумын аялал жуулчлалын самбар байгуулах | | | Төв зам дагуу үйлчилгээний газруудад эко ариун цэврийн байгууламж байгуулах, сумын аялал жуулчлалын самбар байгуулж ажил хийгдсэн. “Говийн зэрэглээ” төсөл хөтөлбөр хэрэгжсэн. | 90 |
| 3.4.1.2 | Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал хөгжүүлэх | | | Одоогоор Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал хөгжүүлэх ажил хийгдээгүй. Говийн зэрэглээ төслийн хүрээнд хийгдэхээр төлөвлөж байгаа. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.4.1.3 | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох “Говийн зэрэглээ” төслийг дэмжин хамтарч ажиллах | | | Цар тахалтай холбогдуулан Аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох “Говийн зэрэглээ” төслийг дэмжин хамтарч ажиллаж Нутгийн иргэд хүрэн бор тэмээнийхээ хоормог сүүгээр нутгийн иргэд болон жуулчдад үйлчлэн хамтран ажиллаж байгаа. | 90 |
| 3.4.1.4 | Цагаан суваргын аялал жуулчлалын маршрут төв зам, эрчим хүчний давуу тал, Тугалын бүлээний рашааныг түшиглэн үйлчилгээний газар байгуулах төсөл, санал санаачлагыг дэмжих | | | Одоогоор Цагаан суваргын аялал жуулчлалын маршрут төв зам, эрчим хүчний давуу тал, Тугалын бүлээний рашааныг түшиглэн үйлчилгээний газар байгуулах төсөл, санал санаачлагыг дэмжих ажил хийгдээгүй. | ХБ |
| **3.5 Эрчим хүч** | | | | | |
| 3.5.1.Зорилт:Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг засварлан шинэчлэх, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг хангах | | | | | |
| 3.5.1.1 | Арга хэмжээ:Сумын төвийн 0,4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг иж бүрэн сольж төмөр бетон тулгууртай СИП кабель шугамтай болгох | | | Шугамын хүчдэл нэмэгдүүлэх ажлын явц 50 хувьтай хийгдсэн. Ирэх онд гүйцэтгэж дуусгахаар одоогоор ажил зогссон. 2022 онд сумын төвийн 0,4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг иж бүрэн сольж төмөр бетон тулгууртай СИП кабель шугамтай болгох ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийж бүрэн шинэчлэв. | 90 |
| 3.5.1.2 | Төрийн байгууллагуудыг болзошгүй үед хэрэглэх тохирсон хүчин чадал бүхий цахилгааны нөөц эх үүсвэртэй болгох | | | Байгууллагуудад хүчин чадал сайтай цахилгааны нөөц эх үүсвэртэй болгох ажил эхнээсээ хийгдэж Эрүүл мэндийн төв, ЗДТГ хүчин чадал сайтай мотортой болсон.Цаашид бусад байгууллагууд анхаарч ажиллана | 90 |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** Зорилго: Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ. | | | | | |
| 4.1 **“Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Зорилт :Ил тод байдлын сумын үнэлгээний үзүүлэлтийг нэмэгдүүлэ | | | Ил тод байдлын үнэлгээний үзүүлэлтийг нэмэгдүүлэх 60 хувьд хүргэнэ. 2021 онд 70 хувьтай хэрэгжиж байна | 70 |
| 4.1.1.1 | Арга хэмжээ: "Цахим Хулд " хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | | | Цахим Хулд хөтөлбөрийг ЗДТГын ажлын хэсгийн хүрээнд боловсруулан бэлтгэж ажилтнууд аймгийн мэдээлэл технологи хариуцсан ажилтнаас зөвлөмж санал авч боловсруулан бэлтгэж байна. Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХТ-ын хурлаар хэлэлцүүлнэ. Ковидын нөхцлийн улмаас хэлэлцүүлэх хурлуудын хугацаа хойшилсон. 2022 оны төсөвт хөрөнгө суулгахаар БИНХ-аас санал авч 10 сая төгрөг төлөвлөж байна. Энэ хүрээнд эхний зорилтын хүрээнд бүх төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулж 100 хувь зөөврийн компьютороор хангах, цахим хуралд 100 хувь хамруулах техникийн боломж бүрдүүлэх, иргэдэд цахимаар төрийн үйлчилгээ лавлагаа авдаг болгох, сүлжээний өргөтгөл хийж бүх газарт сүлжээ оруулах зэрэг ажлыг төлөвлөж байна. 2022 оны ОНХС-ын төсвөөр зарим тоног төхөөрөмж, ухаалаг дэлгэц авч зөөврийн байдлаар иргэдэд мэдээлэл хүргэх, сургалт, цахим хуралд ашиглаж байна. Аймгийн цахим хөтөлбөр цахим шилжилтийн талаар хийгдэж байгаа ажилд хамрагдаж цахим шилжилтын хувь нэмэгдсээр байна. | 90 |
| 4.1.1.2 | Сумын үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх, үйлчилгээний хурд чанарыг сайжруулах | | | Суманд үүрэн холбооны 4 оператор ажиллаж байна. Бүх операторууд 4G, 5G технолгиор үйлчилгээ үзүүлж байна. Суманд ашиглаж байгаа шилэн кабелийн интернетийн үйлчилгээг гэрээгээр үзүүлж байгаа Цахилгаан холбоо сүлжээ ТӨҮҮГазартай 2 удаа уулзалт хийж хүсэлт тавьсны дагуу хуучин 5gb, хурдтай байсныг 10gb болгон өсгөж үнийн хөнгөлөлтэй гэрээ байгуулав. Цахим хурал хийхэд шаардлагатай бодит хаягтай болж цахимаар саатлагүй хуралдах боломж бүрдүүлэв. 06 сард Цахилгаан холбоо, сүлжээ ХК-иас | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | инженерүүд ирж тоног төхөөрөмж бусад үйлчилгээг хийсэн. ЕБСургуульд интернетийн хурд ашиглалтыг сайжруулах ажлыг Мобиком ХХК хийсэн. | |
| 4.1.1.3 | Сумын удирдлагуудын иргэдтэй хийх цахим уулзалт, цахимаар мэдээлэл хүргэх, мэдээлэл солилцох эргэх холбоо бүхий арга хэрэгсэлийг боловсронгуй болгон үр дүнд хүргэх | | | Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу захирамж хуваарь гарган Бямба гарагт Засаг дарга ЗДОрлогч нар иргэдийг хүлээн авч уулзаж байна. Засаг дарга 2 удаа шууд лайваар ИТХуралдаан 3 удаа онцгой комиссын хуралдааныг, 5 удаа цаг үеийн ажлаар иргэдэд мэдээлэл хүргэж асуултанд нээлттэй хариулж ажиллав. Хулд сумын Засаг даргын Тамгын газрын албан ёсны фэйсбуук группыг нээж 2000 гаруй иргэд дагаж мэдээлэл авч байна. Хуучин 500-3500 хүнтэй 3 группээр бичиг хэргийн ажилтан хариуцан байнга цаг үеийн мэдээлэл тавьж эргэх холбоо үүсгэн ажилладаг. 2022 оноос иргэдэд мэдээлэл хүргэх ухаалаг төхөөрөмж бэлтгэн мэдээлэл шинэлэг байдлаар хүргэхээр БИНХ-аас санал авч 20 сая хөрөнгийг төлөвлөсөн байгаа. 2021 онд 3 багийн ИНХуралд бүх алба ажилтнууд мэдээлэл хийж цахим пэйж сайтаар мэдээлэл авах эргэх холбоо үүсгэх талаар танилцуулсан. 2022 онд БИНХурал, малчдын чуулган, ажил идвэхитэй хайгч иргэд, залуу малчдын уулзалт уулзалтын арга хэмжээнд ухаалаг дэлгэц ашиглан сургалт, мэдээллийг явуулж техник технолгийн дэвшил ашиглаж байна. Дундговь аймгийн албан сайт дахь сумын албаны цахим хаягт цаг үеийн болон ил тодын журмаар нээлттэй байх мэдээллийг архив бичиг хэргийн ажилтан хариуцан тогтмол мэдээлэл оруулж байна. | 90 |
| 4.1.1.4 | 4.1.1.4 Архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар, хүндрэлгүй чирэгдэлгүй, үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх | | | Архивын баримтыг цахимжуулах хүрээнд архив бичиг хэргийн ажилтныг тоног төхөөрөмжөөр хангасан. 2009-2012 онуудын удирдлагын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлсэн. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1.1.5 | Архивыг нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | | | 2022 оны ОНХС хөрөнгө оруулалтанд архивын нягтруулсан шүүгээтэй болох, тоног төхөөрөмжөөр хангах 10 сая төгрөг хөрөнгийг шийдсэн 2022 онд хийгдэнэ гүйцэтгэл санхүүжилт хүлээгдэж байгаа. Булаг ундрах ХХК-тай архивын тоног төхөөрөмж хийлгүүлэх гэрээ хийж гүйцэтгүүлэв. Энэ ажлын хүрээнд 2 нягтруулсан шүүгээ, скайнер, шүүгээ зэрэг архивын зориулалтын хөрөнгө оруулалт хийж архивын орчингоо сайжруулж дутагдалтай тоног төхөөрөмжөөр хангав | 90 |
| 4.1.1.6 | Баг байгууллагад багц мессэж үйлчилгээг ашиглан сумын бүх өрхөд шаардлагатай мэдээллийг мессежээр хүргэх эргэх холбоо үүсгэх нөхцлийг бүрдүүлэх | | | Багц мессеж үйлчилгээг хариуцаж байсан цаг уурын ажилтны программыг ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэнд хариуцуулан программ суулган 500 малчин өрхийг холбосон. Программыг ажиллуулах нэгж багцын үйлчилгээний зардлыг БЗДарга, ЗДТГ-ын төсвөөс шийдэж яаралтай зайлшгүй хүргэх цаг уурын гэнэтийн мэдээллийг тухай үед нэгжээр цэнэглэн хүргэж байна. Цаашид энэ үйлчилгээг өргөжүүлэн усмын 750 гаруй өрхийг бүрэн бүртгэж цаг үеийн ажлын мэдээлэл, зар хүргэж ажиллахаар төлөвлөсөн. | 70 |
| 4.1.1.7 | Төрийн үйлчилгээний “Хур” системийн мэдээллийг ашиглан 53 нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, үйл ажиллагааг сайжруулан үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг хувийг жил бүр нэмэгдүүлэх | | | 2020 онд 50 гаруй сая төгрөгний хөрөнгө оруулалтаар e-mongolia төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлж 2021 онд давхардсан тоогоор 21 нэр төрлийн лавлагаагаар давхардсан тоогоор 58 иргэнд гаргаж үйлчилж, иргэн бүрт таниулан сурталчлах ажлыг зохион байгуулан хамтран ажиллаж байна. Цахимаар үйлчилгээ үзүүлэх нөхцлийг төсвийн боломжоор жил бүр бүрдүүлж байгаа.Тайлан мэдээ нэгтгэн гаргаж холбогдох ажилтанд цахимаар тогтмол хүргүүлдэг. E.Mongolia хур системийг ашиглан иргэдэд шаардлагатай лавлагаа тухай бүр хүргэн ажилладаг. | 90 |
| 4.1.1.8 | Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн ”Гэрэгэ” систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл | | | Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн зөрчлийг арилгах ажлын хүрээнд 150 иргэний зөрчлийг хянан үзэж 23 иргэний төрснийг бүртгэсэн он | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | алдаатай, дутуу бүртгэгдсэн иргэний зөрчлийг бүрэн арилгах. | | | сар өдөр алдаатай байсныг засаж холбогдох албан тушаалтанд явуулсан. | |
| 4.1.1.9 | Иргэний улсын бүртгэлийг онлайнд холбож, улсын бүртгэлийн үйлчилгээний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх | | | Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор 2020 оны 10 дугаар сард нэгдсэн сүлжээнд холбогдож 23 төрлийн лавлагаа үйлчилгээг онлайнаар авах боломж бүрдээд байна. E-mongolia төрийн цахим үйлчилгээг иргэдэд сурталчилж гарын авлага 180, үнэмлэхээ хаяж гээсэн 5 иргэн цахимаар үнэмлэх авч, 45 иргэний гар утсан дээр аппликейшн суулгаж, 250 гаруй иргэдэд мэдээлэл хүргэсэн. Мөн оршин суугаа хаягийн лавлагаа иргэний үнэмлэхийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлгүй тухай лавлагаа зэргийг гар утсандаа авч PDF файлаар татах зааврыг 45 иргэнд биечлэн хүргэсэн.Аймгийн улсын бүртгэлийн хэлтсээс зохион явуулсан сарын аяны ажилд хийсэн ажлаа тайлагнан 1-р байр эзэлсэн. | 90 |
| 4.1.1.10 | Ухаалаг дэлгэц ашиглан төрийн үйлчилгээнд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх материалтай танилцаж, хүсэлт илгээдэг болох асуудлыг судлан шийдвэрлэх | | | Ухаалаг дэлгэцээр төрийн үйлчилгээ, бүрдүүлэх баримт, хууль тогтоомжид орсон өөрчлөлт нэмэлтийг авах үйлчилгээг ЗДТГ-т эхлэн нэвтрүүлэхээр техникийн судалгаа хийж байна. 2022 онд ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр багийн ИНХ-аас санал авч ИТХ-аар батлуулахаар ажиллаж байна. 2022 оны ОНХС-ын төсвөөр зарим тоног төхөөрөмж, ухаалаг дэлгэцийг Спийд акцион ХХК нийлүүлж зээврийн байдлаар иргэдэд мэдээлэл хүргэх, сургалт, цахим хуралд ашиглаж байна. Аймгийн цахим хөтөлбөр цахим шилжилтийн талаар хийгдэж байгаа ажилд хамрагдаж цахим шилжилтын хувь нэмэгдсээр байна. | 70 |
| 4.1.1.11 | Эхний ээлжинд ИТХурал, ЗДТГ-ын ажилтнууд, цаашид үе шаттайгаар бүх төрийн албан хаагчдыг зөөврийн комьпютороор улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн шугамаар бүрэн хангаж | | | 2020 онд ЗДТГ-ын ажилтнуудын нийгмийн баталгаа хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах судалгаагаар 9 албан хаагч компьюторын дутагдалтай судалгаа гарсныг хамт олны хурлаар хэлэлцэж төсвийн зохицуулалтаар 10 сая төгрөгөөр 7 ажилтанд зөөврийн | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | орон зай, цаг хугацаа, гамшгийн хүчин зүйлээс үл хамааран төрийн ажил, үйлчилгээг үр дүнтэй цахимаар явуулах боломж бүрдүүлнэ. | | | нотебуук, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ажилтанд нотебуук, 1 ажилтанд хэвлэгч авч өгсөн. 2021 онд ЗДТГ байгууллагын төсвөөр болон хандив тусламжаар 3 хэвлэгч авсан одоогоор зөөврийн компьторгүй хэвлэгчгүй ажилтан байхгүй байна. ЕБСургуулийн багш, СӨБ багш нар 100 хувь хангагдсан. ЭМТөв, Соёлын төв бүрэн хангалттай техниктэй. Ковидын улмаас орон зайнаас үл хамааран цахимаар суралцах, ажлаа гүйцэтгэх боломжтой болсон. Цаашид прогамм хангамжийн мэргэжилтэн дутагдалтай, техник тоног төхөөрөмжөө шинэчлэх ажлыг төсөв, хандив, төсөл хөтөлбөрийн хүрээнд тасралтгүй хийнэ. 2021 онд УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг ЕБСургууль, Цэцэрлэгийн хэрэгцээнд 2 зөөврийн компьютор өгсөн. 2022 онд ОНХСын хөрөнгөөр 2 зөөврийн комьпютор, аймгийн Хүний нөөцийн хөтөлбөрөөр 1, төсвийн хэмнэлтээс 3 нөтебуук авч ажилтнуудаа 100 хувь зөөврийн компьютороор хангав. Мөн улсын бүртгэгч, цагдаагийн ажилтнуудад хангалт хийгдсэн | |
| 4.1.1.12 | Сумын төвд нийтэд зар мэдээ хүргэдэг арга хэрэгслийг боловсронгуй болгон гудамж хорооллыг аравтын системд хамруулах, иргэдийг идвэхижүүлэх арга хэмжээ зохион байгуулах, 4-5 цэгт мэдээлэл хийдэг хэрэгсэлтэй болгох | | | Нийтэд зар мэдээ хүргэх камержуулалттай, гэрэлтүүлэг хослуулан шийдэл бүхий төхөөрөмжтэй болгох асуудлыг төлөвлөн газрын байршлыг тогтоон 20 сая төгрөгний хөрөнгө саналыг БИНХуралд танилцуулан 2022 оны төсөвт тусгахаар болсон. Аравтын системд оруулах зохион байгуулалтын асуудал ковидын улмаас хойшилсон. Гэрэлтүүлэг нийтийн зар мэдээ, камерийн систем бүхий иж бүрэн системийн зураг техникийн тодорхойлолт гарган тендер зарласан боловч шаогарсан компани захиалагчийн зөрүүтэй саналын улмаас тендер цуцлагдсан дараа жил хийгдэхээр 100 сая төгрөгийн хөренгө шилжиж байна | 70 |
| 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба | | | | | |
| Зорилго: Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил бууруулна. | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.2.1 | Зорилт: Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх, томилгооны зөрчлийг бууруулна. | | | 2021 онд суманд шаардлагатай боловсон хүчний судалгааг шинэчлэн гаргасан эмч, багш, сувилагч, малын эмч, ня-бо, бүх төрлийн инженер зэрэг 10 гаруй мэргэжилтэн хэрэгцээтэй байна. Боловсон хүчний нөөц бодлого хөтөлбөр боловсруулах ажил аймгийн бодлоготой холбогдон батлагдаагүй. 2021 онд 2 багийн дарга, ЭМТ-ын даргын үүрэг гүйцэтгэгч, ЗДТГ-ын 4 мэргэжилтэн нийт 7 хүнийг ковидын түр хуулийг үндэслэн хөдөлмөрийн гэрээгээр түр томилон ажиллуулж байна. Зөрчлийг хуулийн үйлчлэл халдварт өвчин, ковидын нөхцлөөс шалтгаалан бууруулах юм. Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай мэргэжилтэнг дэмжих захиалга өгөх ажлыг хийж байна. Орон нутагтаа ажиллах хүсэл эрмэлзэлтэй залуучуудыг дэмжин түр ажиллуулж байгаа. 2022 онд төрийн захиргааны ажилд түр ажиллаж байсан 4 залуучуудыг ажлаас чөлөөлж сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргэсэн. Орон нутагт ажиллах хүний нөөцийн судалгаа хийсэн хүний нөөц туйлын хангалтгүй байна. Одоогоор ЗДТГ-7, ЕБС-д 3, ЭМТ-4, Соёлын төвд 2 нийт төрийн албанд 16 сул орон тоо байна. | 70 |
| 4.2.1.1 | Арга хэмжээ:Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх | | | 2021 онд холбогдох журмын дагуу төрийн албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах журмын дагуу Нийгмийн бодлогын мэргэжилтэнг хоёр байгууллагын тохиролцсноор Улсын бүртгэгч болгон шатлан дэвшүүлсэн. Судалгаагаар 5 дээш жил нэг баййгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч сумын хэмжээнд 50 хувийг эзлэж байна. Багийн Засаг дарга нарын сонгууль ковидын улмаас 7 сар хүртэл хойшилсон. 11 сард хөл хорио тавигдаж БИНХурлуудыг хийж 3 багийн Засаг дарга, ИНХ-ын дарга нар сонгогдсон хуулийн дагуу АТГ-т ХАУМ явуулж Засаг дарга томилгоо хийнэ. 2022 онд БИНХ-ыг хуулийн дагуу хийж 3 багийн даргыг ХАСУМ авч томилсон. Мөн ЭМТ-ын даргын үүрэг гүйцэтгэгч 1, ня-бо 1, төрийн сангийн мэргэжилтэн 1, Санхүү албан дарга 1, нийт 7 албан тушаалтанг хуулийн дагуу томилгоожуулав. 12 сард | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Нийгмийн даатгалын байцаагчийг шилжүүлэн Санхүү албаны дарга, ЗДТГ-ын даргын үүрэг түр орлон гүйцэтгэгчээр, ЗДТГ-ын даргыг сэлгүүлэн ажиллуулах журмын дагуу төрийн сангийн мэргэжилтнээр ажиллуулж байна. | |
| 4.2.1.1 | Арга хэмжээ:<br><br>Гадаад хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжин ажиллах | | | Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр гаргасан тогтоол журмыг хүлээн авсан 2021 онд гадаад хамтын ажиллагааны хүрээнд хийсэн гэрээ байхгүй байна. 2021 нд Швейцарийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн оролцоотой “Говийн зэрэглээ” төсөл хэрэгжсэн. Ингэний сүүгээр бяслаг үйлдвэрлэх НҮБ-ын оролцоотой төсөл хэлцлийн шатанд байна.1 удаа уулзалт судалгаа үнэлгээ хийгдсэн. 2022 оны гадаад үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Засаг даргаар батлуулан ажилласан. Гадаад нөхцөл байдал төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 2022 онд гадаад арга хэмжээ зохион байгуулагдаагүй төлөвлөгөөний хрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр ТЗУХ-д хүргүүлсэн | 70 |
| 4.2.1.2 | Арга хэмжээ:<br><br>Ажилтнуудыг болон шинээр албанд томилогдсон иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах, чадавхижуулах | | | 2021 онд Удирдлагын академийн богино хугацааны сургалтанд нийт 5 ажилтны захиалга өгсөн ковидын улмаас хойшилсон. Цахим сургалтанд 2 ажилтан хамрагдсан. Шинээр төрийн албанд ажиллаж байгаа 3, түр ажиллаж байгаа 4 ажилтанд ажлын байранд сургах талаар хамт олны хурлаар хэлэлцэж 4 ахмад ажилтанд хариуцуулан ахмад мэргэжилтний зөвлөх туслах үйлчилгээнд хамруулсан 2 удаа сургалт ажлын байранд байнга сургалт зөвлөгөө өгч ажилласан. 12 сар шинэ залуу 8 ажилтанг аймгийн ХШҮ-ны хэлтэсийн сургалтанд хамруулан Сайнцагаан сумын ЗДТГ-ын туршлага судлуулах ажил хийгдэнэ. Зохих үр дүн гарч байна. 2021 онд санхүү албаны дарга дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтанд амжилттай суралцаж сертификат авсан. ХААТ-ын мэргэжилтэн Б.Сангад сургалтанд цахимаар хамрагдаж байна. 2022 онд НД- | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ын байцаагч Э.Хонгорзул Удирдлагын академийн богино хугацааны сургалтанд хамрагдаж гэрчилгээ сертификат авсан. | |
| 4.2.1.3 | Арга хэмжээ: Сумын дотоод, гадаадад амжилттай суралцагч, сум орон нутагтаа ажиллаж амьдрах хүсэлт гаргасан оюутан залуучуудтай гэрээ хийж, орон нутагт тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллах сонирхол төрүүлэхүйц нийгмийн болон эдийн засгийн боломж бүрдүүлэнэ. | | | Сумын харьяат гадаад дотоодын их дээд сургуульд суралцаж байгаа оюутан залуучуудын судалгаар багийн Засаг дарга нараас авч байна. Оюутан залуучуудын уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Ковидын улмаас тодорхойгүй хойшилсон. Сумын цахим группэд сумын сайтаар сул ажлын байрны болон төрийн албаны шалтгалтын мэдээллийг тогтмол тавьж иргэдэд хүргэдэг. Төгссөн боломжит залуучуудад утсаар санал мэдээлэл хүргэж дэмжиж ажилладаг. Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай мэргэжилтэнг дэмжих захиалга өгөх ажлыг хийж байна. Орон нутагтаа ажиллах хүсэл эрмэлзэлтэй залуучуудыг дэмжин ЗДТГ-т 3 залууг түр, 1 ажилтанг бүр, ЭМТөвд 2 эмч зохих гэрээ хийж ажиллуулж байгаа. Ирж ажиллах залуучуудад сум бүх л боломжтой хэлбэрээр дэмжин ажиллах зорилготой байна. 2022 онд Удирдлагын акедемийг төрийн захиргааны удирдлагаар төгссөн Б:Бямбасүрэн, Сүхбаатар аймагт ажиллаж байгаад ирсэн малын эмч Х.Мягмарсүрэн нарын нутгийн залуу боловсон хүчнийг төрийн албанд ажиллуулах дэмжих талаар уулзалт ярилцлага хийж Нийгмийн бодлогын мэргэжилтэн, МЭТ-ын байцаагчаар түр томилон төрийн албаны нөөцийн шалгалт өгүүлэхээр болов. Суманд 5 хүнтэй авах бүлэг бий болгон ажиллаж байна | 90 |
| 4.2.1.4 | Арга хэмжээ:<br><br>Төрийн албан хаагчдын оффисын техник хэрэгсэл ашиглах чадварыг сайжруулах, албан бичиг хэрэг боловсруулах сургалтуудыг зохион байгуулж чадвар бүтээмжийг нэмэгдүүлэх | | | 2020 онд төсвийн зохицуулалтаар 10 сая төгрөгөөр 7 ажилтанд зөөврийн нотебуук, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ажилтанд нотебуук, 1 ажилтанд хэвлэгч авч өгсөн. Одоо 1 ажилтан дутуу байна. ЕБСургуулийн багш, СӨБ багш нар 100 хувь хангагдсан. Ковидын улмаас орон зайнаас үл хамааран цахимаар суралцах, ажлаа гүйцэтгэх боломжтой болсон. 2021 оны 03 сарын | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамт олны хурлаар ажилтнуудын техник хэрэгсэл ашиглах талаар мэдлэг туршлагаа хуваалцаж чадвараа нэмэгдүүлэх санал гарсны дагуу залуу ажилтнууд ажлын байран дээрээ мэдлэгээ хуваалцахаар болж хэрэгжүүлж байна. Шинээр төрийн албанд ажиллаж байгаа 3, түр ажиллаж байгаа 4 ажилтанд ажлын байранд сургах талаар хамт олны хурлаар хэлэлцэж 4 ахмад ажилтанд хариуцуулан ахмад мэргэжилтний зөвлөх туслах үйлчилгээнд хамруулсан 2 удаа сургалт ажлын байранд байнга сургалт зөвлөгөө өгч ажилласан. Он гаргаад аймгийн ахмадууд болон Улаанбаатар хотын сургалтанд залуучуудыг хамруулах төлөвлөгөөтэй байна. Байгууллагын сургалтын төлөвлөгөө хэрэгжилт 90 хувьтай байна. 2022 онд ОНХСын хөрөнгөөр цахим Хулд хөтөлбөрийн хүрээнд ухаалаг дэлгэц, өнгөт принтер, 2 зөөврийн комьпютор, аймгийн Хүний нөөцийн хөтөлбөрөөр 1, аймгийн ЗДТГ-аас өндөр хүчин чадалтай дэлгэц проектор балансаас балансад шилжүүлэн авсан мөн төсвийн хэмнэлтээс 3 нөтебуук авч ажилтнуудаа 100 хувь зөөврийн компьютороор хангав. ЗДТГ-т архивын 10 сая төгрөгний тоног төхөөрөмж 3 принтер шинээр авсан. Дотоод сургалтын аргаар техник хэрэгсэл ашиглах сургалт зөвлөгөөн зохион байгуулдаг | |
| 4.2.1.5 | Иргэд төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах | | | Сургалтын ажил ковидын улмаас хойшилсон. Хөл хорио суларсантай холбогдуулан аймагт сумын удирдлага 5 хүн Хүний нөөцийн институтын болон лектор О.Бандицэрэнгийн лекцэнд хамрагдсан. Суманд 12 сард 40 ахлах ангийн сурагч, 65 төрийн албан хаагчдад лектор О.Бандицэрэнгийн Цаг хэд болж байна лекцэнд хамруулав. Албан хаагчдад зэрэг хандлага, санаачлагыг дэмжин ажиллаж байна. Нийт санаачилга сургалтын тоо 5. Малчдын чуулган бусад арга хэмжээ, Эрдэнэдалай суманд болсон бүсийн уулзалт, Улаанбаатар хотод болсон нутгийн удирдлагын сургалт уулзалт зэрэг арга хэмжээний үеэр | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | давхардсан тоогоор 100 төрийн албан хаагч 400 иргэнд доктор Бат-отгоны болон хоршооны зөвлөх багш Баасанхүү, зан загил судлаач С.Дамбий зэрэг лектор багш нарыг урьж хандлага ёс зүй хүмүүжил төлөвшлийн сургалт лекцүүдийг уншуулж хамруулсан | |
| 4.2.1.6 | Залуучууд чадвартай боловсон хүчнийг орон нутагт ажиллуулах дэмжих талаар бүх эх үүсвэрээс сан, хөрөнгө нөөц төвлөрүүлэн дэмжлэг үзүүлэх | | | Сумын харьяат гадаад дотоодын их дээд сургуульд суралцаж байгаа оюутан залуучуудын судалгаар багийн Засаг дарга нараас авч байна. Оюутан залуучуудын уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Ковидын улмаас тодорхойгүй хойшилсон. Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хүрээнд зарцуулж буй сургалтын хөнгөлөлтийн төлбөрийн хөнгөлөлтөнд хамруулах боломжтой оюутны судалгааг авч байна. Сум өөрөө хүний нөөцийн хүрээнд зарцуулах хөрөнгө 2022 оноос төсөвлөх төвлөрүүлэх шаардлагатай одоогийн 2021 оны хэмнэлтийн төсвийн хүрэээнд боломжгүй байв. Сан бүрдүүлэх асуудлыг холбогдох байгууллага иргэдэд санал тавьж бүрдүүлэх талаар ажиллаж байна. 2021 онд Солонгос улсад 2, Япон улсад 3 залуу суралцаж байгаа судалгаа байна. | 70 |
| 4.2.2 | Зорилт:Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог сайжруулж, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх. | | | Шударга байдлын үнэлгээг 60 хувь байсныг 70 хувьд хүргэж нэмэгдүүлэх | 70 |
| 4.2.2.1 | Арга хэмжээ:<br><br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлэх ажил зохион байгуулж, санаачлагыг дэмжин ажиллана. | | | Авлигын эсрэг төлөвлөөг 18 заалттайгаар төлөвлөж хэрэгжүүлэв. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Засаг даргын зөвлөл удирдлагад танилцуулан ажилласан. Тайланг ХЭЗХ-д хүргүүлсэн. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.2.2.2 | Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулна. | | | Суманд 2 ЭБАТ ажилладаг. 2021 онд хуулиар хамрагдах 31 албан тушаалтнаас ХАСХОМ гаргуулан хуулийн хугацаанд цахимаар мэдүүлсэн. ЗДОрлогч, 2 БЗДарга нийт 3 улс төрийн албан хаагчийг ХАСУМ-ыг цахим болон цаасаар авч томилгоо хийсэн. 2 ЭБАТ 5-14 жил ажилласан туршлагатай тогтвор суурьшилтай ажиллаж байна. 2022 онд БИНХ-ыг хуулийн дагуу хийж 3 багийн даргыг ХАСУМ авч томилсон. Мөн ЭМТ-ын даргын үүрэг гүйцэтгэгч 1, ня-бо 1, төрийн сангийн мэргэжилтэн 1, Санхүү албан дарга 1, нийт 7 албан тушаалтанг хуулийн дагуу томилгоожуулав. 12 сард Нийгмийн даатгалын байцаагчийг шилжүүлэн Санхүү албаны дарга, ЗДТГ-ын даргын үүрэг түр орлон гүйцэтгэгчээр, ЗДТГ-ын даргыг сэлгүүлэн ажиллуулах журмын дагуу төрийн сангийн мэргэжилтнээр ажиллуулж байна. | 90 |
| Зорилт:4.2.3 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд зохион байгуулах | | | Эрх зүйн 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Заавал судлан мэдэх салбаруудын хууль тогтоол журмуудыг ажил хариуцсан мэргэжилтнүүдээр бэлтгүүлэн цахимаар 8 хууль журмын мэдээлэл бэлтгэн сумын 500-3500 гишүүнтэй 4 групп ЗДТГ-ын дотоод болон албан группд тавьж иргэд албан хаагчдад сурталчилж байна. Мэдээллийн цаг, шуурхай цуглаанаар 3, 5 сард 2 удаа цаг үеийн ажил, Нийгмийн халамжийн хууль тогтоомж, Нийгмийн даатгалын журмын өөрчлөлтөөр, авлига ашиг сонирхлын тухай эрх зүйн хөтөч багаас мэдээлэл сурталчилгаа хийгдсэн. 10 сараас өвчний хорио тавигдсантай холбоотой эрх зүйн сургалт сурталчилгааг идэвхижүүлэн ажиллав. 10 сард болсон Шувуутай багийн ИНХ-д оролцсон 250 малчид иргэдэд эрх зүйн хөтөч баг хууль сурталчлах гарын авлага тараах материалтай тусгай вагончик авачин оролцож 6 ажилтан Нийгмийн даатгал халамж, газар, улсын бүртгэл, татвар, байгаль орчин, ХАА-н талаар 50 иргэнд багийн хурлын үеэр үйлчилгээ үзүүлж 300 гарын | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | авлага материал бэлтгэн тараасан. 11 сард болсон 2 багийн ИНХ нийт 430 иргэнд мэдээлэл гарын авлага тараасан зөвлөмж өгсөн. 11 сарын 25 нд иргэдэд хэрэгцээтэй 5 хуулиар хууль сурталчлах “Дэвжээ” тэмцээний удирдамж гарган зохион байгуулж 5 байгууллагын 40 ажилтан оролцон хууль суралчлан цахимаар олон түмэнд хүргэн сурталчлав. Эрх зүйн хөтөч нарын гэрээг дүгнэн оны эцэст урамшуулахаар болов. 10-11 сард зохион байгуулсан 3 багийн БИНХ-ын үеэр нийт 670 иргэнд цаг үеийн мэдээлэл хүргэн зөвлөмж гарын авлага бэлтгэн тараасан. Хулдын сайт 1000-3500 иргэний хандалттай 3 сайтаар хуулийн шторк зөвлөмж мэдээллийг давталттайгаар иргэдэд тогтмол хүргэж байна.Эрх зүйн хөтчийн ажиллах төлөвлөгөөг оны эхэнд болосруулан баталсан. 2 удаа аймгаас зохион байгуулсан чиглүүлэх чадваржуулах сургалтанд бүрэн хамруулсан. Хөтөчтэй гэрээ байгуулан ажлыг хуваарьлан төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааг цахимаар голлон хийж байна. Танхимын сургалт, зөвлөгөө , хуулийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээ өвчний улмаас хойшилсон. 2022 онд эрх зүй мэдээллийн үйл ажиллагааны хуваарь төлөвлгөөг сумын Засаг даргын захирамжаар батлан 14 хоногт 1 удаа мэдээлэл хийх цаг үеийн ажилын үед гарын авлага тараах мэдээлэл хийх ажлуудыг тогтмол эрх зүйн хөтөч баг хариуцан гүйцэтгэж байна. | |
| 4.2.3.1 | Арга хэмжээ:<br><br>Хөдөөгийн малчид, иргэдэд чиглэсэн олон нийтийн, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн, урлаг соёлын арга хэмжээ, нэгдсэн төрийн үйлчилгээг явуулаар үзүүлэх, байр, техникийн шийдэл олж, хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр багуудад 1-2 удаа зохион байгуулах | | | Явуулаар хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий асар техник тоног төхөөрөмжийн танилцуулгыг ИТХурал , багийн хурлууд Засаг даргын зөвлөлд танилцуулан техникийн тодорхойлолт нөхцлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэн 50 сая төгрөгний хөрөнгийг 2021 оны төсөв суулгасан. Тендерийг хуулийн дагуу 6 сард зарлаж гүйцэтгэгчээр “Төгс дардас” ХХК шалгаруулан гэрээ байгуулсан. 100 хүнд үйлчлэх зориулалт багтаамж бүхий чанартай Явуулын асрыг 7 сард нийлүүлж ажлын хэсэг хүлээн авсан. Сургалт үйл ажиллагааг Соёлын төвд | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хариуцуулан гүйцэтгүүлэхээр хүлээлгэн өгсөн. Хагас жилээс хойш суманд Олдох багт шашин урлагын тоглолт, Шувуутай багт БТНХ-ын зориулалтаар ашигласан, аймгийн зохион байгуулсан арга хэмжээнд 8-9 сард сүм хөх бүрдэд ашигласан. Олон нийтийн хүсэлд нийцсэн ажил болсон. 2022 оноос багуудад 2 удаа арга хэмжээ зохиохоор төлөвлөж байна. Ковид өвчний дэгдэлтийн улмаас төлөвлөсөн сургалт сурталчилгааны ажлууд хойшилсон. 2022 онд 9 сард 400 малчин оролцсон малчдын чуулган, 10 сард 40 залуу малчин оролцсон залуу малчдын уулзалт, зөвлөгөөн, 40 ажил идвэхитэй хайгч иргэн оролцсон хэлэлцүүлэг тус тус хөтөлбөр удирдаж гарган амжилтай зохмион байгуулж сургалт мэдээлэл, хэлэлцүүлэг зохион байгуулав. Энэ үеэр иргэд малчдад зориулсан сургалт соёл урлагийн томоохон арга хэмжээг зохион байгуулж иргэдээ хамруулсан. Арга хэмжээнд малын тоо толгойн татвараас 30 сая төгрөг хөрөнгө зарцуулав. | |
| 4.2.3.2 | Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах | | | Тус аяны талаар төрийн байгуулагын дарга нар, БЗД нарт үүрэг чиглэл хүргүүлэн тодорхой ажлыг зохион байгуулан ажиллав. Үүнд: Тус аяны хүрээнд Жендерийн талаар хялбаршуулсан гарын авлага бэлтгэж Жендерийн нэр томьёоны ойлголт, жендерийн үзэл баримтлалыг бодлого үйл ажиллагаанд хэрхэн тусгах, нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, жендерийн ялгаварлан гадуурхалт,улс төр, ЭЗ, төрийн алба, хөдөлмөрийн харилцаа, Соёл, боловсрол, эрүүл мэндийн салбар болон гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа гэх зэрэг мэдээллийг төрийн албан хаагчид болон иргэдэд хүргэсэн. ЭМТ,ЕБС-ийн захиргаа нийт 23 эрчүүдийн дунд эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө, ярилцлага зохион байгуулсан . | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.2.3.3 | Орон нутгийн ИНБ-уудын оролцоо хамтын ажиллагаанд тулгуурлан жендэрийн боловсрол олгох, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, аяныг гэрээлэн гүйцэтгүүлэх | | | Байгууллагуудын эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн анхан шатны урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж хорт зуршлаас татгалзах, түүний хор нөлөө, хөдөлгөөний хомсдол, стрессээс ангид байх зэрэг мэдээ мэдээллийг хүргэн ажилласан. Энэ аянд бүгдээрээ нэгдээрэй. МУ-ын Ерөнхий сайдын захирамжаар батлуулсан " Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд ГБХЗХГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газраас сумдын ЗДТГ-тай хамтран Монгол цэргийн өдрийг тохиолдуулан доорхи арга хэмжээг зохион байгуулж байна аа. /Албан бичигтэй танилцана уу/Төрийн албан хаагчдын манлайллыг сайжруулах зорилгын дор Дундговь аймгийн “Говийн хийморь” АА бүлгийн урьж ТАХ-ын эрчүүдийн дунд сургалт зохион байгуулж, амьдралын зөв дадлыг бий болгох, гэр бүлдээ сайн сайхныг түгээх, бусдад сайнаар нөлөөлж манлайлах, бусдыг сайн зүйлд уриалах сэдвээр 4 зорилгын хүрээнд зохион байгуулагдлаа.Сургалтанд 23 ТАХ-д оролцсон. Сугалтын үр дүн бол суманд “АА” бүлэг байгуулах байсан. 3 ТАХ-д бүлэгт нэгдэн зөвлөгөө авсан. ЗДТГ-ын хамт олны хурлаар сануулга авсан албан хаагчидтай баталгаа авч гарын үсэг зуруулж гэрээ байгуулахаар болсон. Бид цаашид үр дүнг тооцож, дээрх “АА"-гийн бүлэгтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна. | 90 |
| **4.3 Амар тайван, аюулгүй нийгэм**<br>Зорилго **Цагдаагийн хэсгийн материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлэх** | | | | | |
| 4.3.1 | **Зорилт:**Гэмт хэрэг болон зам тээврийн ослын хэмжээг бууруулна. | 0,5сая төгрөг | | Суманд 2021 онд гарсан гэмт хэрэг 5, 2020 оны мөн үед 6 гэмт хэрэг бүртгэгдсэн буурсан үзүүлэлттэй. Гэмт хэргийн зонхилох хувь нь жижиг хулгайн хэрэг байна. /Хэсгийн мөрдөгчийн гэмт хэргийн сонсгол мэдээллийг Засаг даргын зөвлөлөөр хагас бүтэн жилээр хэлэлцүүлэн ГХУСЗөвлөлд улирал бүр хэлэлцүүлж танилцдаг. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.3.1.1 | Арга хэмжээ:<br>Архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн хөтөлбөр боловсруулан, цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | | | Ковидын улмаас төлөвлөсөн ажил хойшилсон боловч аймгийн АА нийгэмлэгтэй хамтран төрийн байгууллагын эрэгтэйчүүдтэй 2 удаа уузалт хурал зохион байгуулсан. Нийтийг хамарсан ажил зохион байгуулагдаагүй байна. Засгийн газрын 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагад архитай арга хэмжээ зохион байгуулахгүй байх талаар үүрэг чиглэл өгч ажилласан. 1 байгууллагад албан тоотоор сануулах арга хэмжээ авсан. | 70 |
| 4.3.1.2 | Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжин ажиллах | | | ГХУС ажлын төлөвлөгөөг ИТХТэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Ковид хөл хорионы улмаас төлөвлөсөн ажлууд хойшилж байгаа. Отор нүүдлийн улмаас өөр сум, аймгийн нутагт отор нүүдэл хийж байгаа малчин өрхийн өвөлжөө хаваржааг эргэж тойрч хяналтанд авч эздэд нь хариу мэдэгдсэн. 2 хулгайн гэмт хэргийг илрүүлэн хэрэг бүртгэлт хийсэн. Одоогоор ноцтой гэмт хэрэг зөрчилгүй байна. Биечилсэн арга хэмжээ аяны хүрээнд ковидын улмаас хөдөлгөөн хязгаарласан үед гадуур зорчиж байгаа иргэдэд халдвар хамгааллын дэглэм сахиулах талаар 3 хоног аймгийн 2 албан хаагчтай хамтран хөдөлгөөнт эргүүл хийсэн. | 90 |
| 4.3.1.3 | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | | | Төв зам, сум тойрсон хүнд даацын тээврийн замд тогтмол хяналт тавьж 7 хоногт 2 доошгүй эргүүл хяналт тавьж ажиллаж байна. Ковидын улмаас энэ жилд аймгаас 2 удаа туслах цагдаа авчран эргүүл хяналтын үүрэг 7-21 хоногоор 2 удаа ажиллуулсан. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс 50 хувь буурсан. Гэмт хэргийн бууралт ковидын хөл хорио сумын төвөөр том оврын машин явуулахгүй байгаа 2021 онд байнга постын хяналттай байсантай холбоотой байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, зам | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тээврийн ослоос сэргийлэх хүрээнд цагдаагийн хэсэг Хүүхэд хамгааллын баг хамтран анхааруулах самбар 3, тэмдэг 2, замын аюултай хэсэгт толь тавих ажлыг байгууллага иргэдийн хандив дэмжлэгээр хийв | |
| 4.3.1.4 | Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, оролцоотой гэр хорооллын гудамж, сумын төв талбай, төрийн байгууллага, худалдаа үйлчилгээний газруудыг дэвшилтэт технологи бүхий камержуулалт, гэрэлтүүлгийн системтэй хослуулан үр дүнтэй хяналтын системийг нэвтрүүлэх | | | 2021 онд гэр хорооллын гэрэлтүүлэг камержуулалт мэдээлэл дамжуулах смстем байгуулах санал асуулга авч БИНХ-аар дэмжүүлэн хийхээр 2022 онд төлөвлөсөн. Бүх байгууллага дотоод гадаад камерийн хяналтаар бүрэн хангагдсан. 2020 онд сумын төвийг бүрэн хянах 6 камер бүхий системийг ОНХС-аар хийж хяналтыг цагдаагийн кабонд хийж байна. Камержуулалтын үр дүнд сумын төвд гардаг зөрчлийн хэрэг 50 хувь буурсан. Төвийн гэрэлтүүлэг засвар ажлыг 3 сая төгрөгийн ЗДТГ-ын урсгал засварын төсвөөр хийсэн. | 90 |
| 4.3.1.5 | Мал хулгайлах, эд зүйлийн хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдийн төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах | | | 10-11 сард болсон БИНХурлаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хуулиар мэдээлэл өгч малчидтай хамтран ажиллах талаар хэлэлцэж санамж гарын авлага тараан ажиллав. 11 сарын 25 болсон хууль сурталчлах “Дэвжээ” тэмцээний сурталчлах 1 хуулийг энэ хуулиар бэлтгүүлэн иргэдэд сурталчлав. Ковид өвчний хөл хорио хяналт шалгалтын үр дүнд мал хулгайлах хэрэг 2021 онд 2 гарсан нь өмнөх үеэс 50 хувиар буурсан. | 90 |
| 4.3.1.6 | Хэсгийн мөрдөгч, цагдаа нарын албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, цагдаагийн кобаны тохижилт, замын постын үйл ажиллагааг тогтмолжуулж сайжруулах талаар анхаарч иргэд олон нийтийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх | сумын ЗДТГ хариуцан гүйцэтгэнэ. | | 2021 онд цагдаагийн хэсгийн хэрэгцээнд Орон нутгийн төсвөөс сар бүр бензины зардалд 150-200 мянган төгрөг, цахилгаан халаалтын зардлыг бүрэн хариуцаж ажилладаг. 2013-2020 онд цагдаагийн иж бүрэн тоногтой приус автомашин, prado машинтай 2021 онд машин засварт 2 сая төгрөг шийдэж өгсөн. Согтууралыг хэмжих драйгар шийдэж өгсөн. Цагдаагийн эхнэрийг Тэс петролиум ШТС-д ажлын байраар хангасан. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4.3.3. Зорилт: Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал** | | | | | |
| 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ. | | | | | |
| 4.3.3.1 | Арга хэмжээ:<br><br>Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах сэрэмжлүүлэх, асуудлыг багц мессеж үйлчилгээг ашиглан 100 хувь шийдвэрлэнэ. | | | Багц мессеж үйлчилгээг хариуцаж байсан цаг уурын ажилтны программыг ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэнд хариуцуулан программ суулган 500 малчин өрхийг холбосон. Программыг ажиллуулах нэгж багцын үйлчилгээний зардлыг БЗДарга, ЗДТГ-ын төсвөөс шийдэж яаралтай зайлшгүй хүргэх цаг уурын гэнэтийн мэдээллийг тухай үед нэгжээр цэнэглэн хүргэж байна. Цаашид энэ үйлчилгээг өргөжүүлэн сумын 750 гаруй өрхийг бүрэн бүртгэж цаг үеийн ажлын мэдээлэл, зар хүргэж ажиллахаар төлөвлөсөн. | 70 |
| 4.3.3.2 | Гамшгаас хамгаалах мэргэжил ангийн 66 хүний нөөцийг жил бүр тодотгон шинэчлэж зориулалтын хувцас, тоног хэрэгсэлээр бүрэн хангаж гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулна. Сургалтанд мэргэжил ангийн бүрэлдэхүүнийг 100 хувь, | | | 2021 онд ковидтой тэмцэх ажилд нөөц бэлтгэх 10 сая төгрөг, мэргэжил анги онцгой комиссын бэлэн байдал хувцас тоног хэрэгсэл сайжруулах хөрөнгө 10 сая нийт 20 сая төгрөг ОНХСангаас гэрээ байгуулан нийлүүлж нөөц хангалт бий болгов. Малын өвчний үеэр 8 голомтод шуурхай пост хариу арга хэмжээний баг зохион байгуулж ажиллав. 2022 оны 11 сарын 4-5 нд Монгол улсын шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний дагуу гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2 өдөр амжилттай зохион байгуулав. Сургуулийн үеэр Ерөнхий мэргэжил ангийн тодотголыг Засаг даргын захирамжаар тодотгон бэлэн байдлын сургууль хийв. Иж бүрэн суруулийн тайланг бэлтгэн Онцгой байдлын газарт явуулсан сургуулийг удирдагчийн зүгээс хангалттай гэж үнэлэв. | 90 |
| 4.3.3.3 | Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, 2 жилд 1 удаа дадлага сургууль, үзлэг зохион байгуулах | | | 2022 оны 11 сарын 4-5 нд Монгол улсын шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний дагуу гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2 өдөр амжилттай зохион байгуулав. Сургуулийн үеэр | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Ерөнхий мэргэжил ангийн тодотголыг Засаг даргын захирамжаар тодотгон бэлэн байдлын сургууль хийв. Иж бүрэн суруулийн тайланг бэлтгэн Онцгой байдлын газарт явуулсан сургуулийг удирдагчийн зүгээс хангалттай гэж үнэлэв. | |
| 4.3.3.4 | Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион, байгуулах, хүч хэрэгслээр хангах | | | Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд суманд байгуулагдах 10 хүнтэй аврах бүлэг байгуулахаар болсон. Аймгийн Засаг дарга, ОБГ-ын дарга, сумын Засаг дарга нарын хэлэлцэн тохирсоноор сум аврах бүлгийн байрыг бэлтгэх, аймгийн дарга унааны асуудлыг ,ОБГазар төсөв, тохижилтын асуудлыг хариуцах болсон. Сумнаас 2 байршилд байшин судлаж байршил сайтай хув иргэний өмчийн байшинг худалдан авч засварлах болсон хөрөнгийг шийдвэрлэхээр судлаж байна. Эрэн хайх аврах ангийн байр, газрын асуудлыг сумын ОНХС-н 30 сая төгрөгөөр орон нутаг шийдсэн засвар тохижилт гарашыг Онцгой байдлын газар хийж аймгийн Засаг дарга унаа техникийн асуудлыг шийдсэн. 2022 оны 8 сараас суманд 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллуулж эхэлсэн. Одоогоор 2 машин аврах тоног төхөөрөмжтэй ажиллаж байна | 90 |
| 4.3.3.5 | Хүн, малын халдварт өвчин, цар тахлын үеийн болзошгүй бэлэн байдлын хангалтыг зохих түвшинд бүрдүүлэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн эрсдлийг бууруулах нөхцөл бүрдүүлнэ | | | 2021 онд ковид цар тахал нийт хүн амын дунд, малын халдварт шүлхий, мялзан өвчин 3 багт голомтлон гарч Засаг даргын захирамжийн дагуу Онцгой комиссын хурлыг 17 удаа хийж тус бүр зохион байгуулалтын болон хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоон хяналт тавьж дэглэм журмыг ЭМТөв, МЭҮНэгжүүд томилогдсон ажилтнууд хэрэгжүүлэн ажиллав. Хөрөнгийн хувьд 2 удаа төрийн байгуулллагын төсвийн 1 хувийг төвлөрүүлэн 10 сая орчим төгрөг, улс иргэдийн цуглуулсан 10 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө 3 сая, ЗДТГ-ын төсөв 2 сая, нийт 25 сая орчим төгрөг бүрдүүлэн эрсдлийг бууруулах хүрээнд зохих зардалд зарцуулан ажиллав. 2021 оны төсөвт хамгаалах хэрэгсэл оношлогооны нөөц 10 сая, мэргжил ангийн | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | бэлэн байдал хувцас тоног хэрэгсэлээр хангах 10 сая нийт 20 сая төгрөгийг ОНХС-ын хөрөнгөөр гэрээ байгуулан авч хангалт нөөц бүрдүүлэв. | |
| **4.4: Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого** | | | | | |
| 4.4.1 | ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаадын аймаг, муж, хот тосгонтой хамтын ажиллагаатай болж, гадаадын хөрөнгө оруулалттай болох ажлыг судлах | | | Ажлыг судалж байна. Хамтран ажиллаж болох ажлын талаар мэдээлэл авч байна. Ковид халдварт өвчин суманд гарсантай холбоотойгоор сургалт, арга хэмжээний асуудлууд тодорхойгүй хугацаагаар хойшилж байв. | 50 |
| 4.4.1.1 | Арга хэмжээ:<br><br>Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, тосгон олон улсын төслийн байгууллагатай түншлэх асуудлыг судлах | | | Ажлыг судалж байна. Ковид халдварт өвчин суманд гарсантай холбоотойгоор сургалт, арга хэмжээний асуудлууд тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Хамтран ажиллаж болох ажлын талаар мэдээлэл авч байна. | 50 |
| 4.4.1.2 | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулах | | | Ковид халдварт өвчин суманд гарсантай холбоотойгоор сургалт, арга хэмжээний асуудлууд тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Хамтран ажиллаж болох ажлын талаар мэдээлэл авч байна. | 50 |
| **4.5 Батлан хамгаалах** | | | | | |
| 4.5.1 | Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамжийг сайжруулах | | | 2005 онд хийж аймгийн Засаг даргаар батлуулсан жил бүр тодотгол хийсэн Улсын болон ЗХ-ниий хүн, техникээр нөхөн хангах Дайчилгааны төлөвлөгөөг тодотгон ашиглаж байна. 2021 оны 12 сард шинээр боловсруулах батлуулахаар аймгийн Цэргийн штабт нууцийн журмын дагуу хүргэсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувь<br><br>Дайчилгааны нөөцийн судалгааг тухай бүр судлан бүртгэж байгаа. Ажлыг судлаж байна. Ковид халдварт | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | өвчин суманд гарсантай холбоотойгоор сургалт, арга хэмжээний асуудлууд тодорхойгүй хугацаагаар хойшилсон | |
| 4.5.1.1 | Арга хэмжээ: Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчилан таниулах | | | 2021 оны намрын цэрэг татлагын үеэр ахлах 8-9 ангийн хөвгүүд сурагчдад цэргийн штабаас 2 цагийн сургалт хүмүүжлийн ажил зохион байгуулсан. Хичээлийн агуулгад энэ хөтөлбөрийн талаар оруулан сургалт хүмүүжлийн ажил зохион байгуулах талаар насан туршийн боловсролын ажилтан, нийгмийн ажилтан харт чиглэл өгсөн. 12 сар Бандицэрэн лекторын сургалтанд анхлах бүлгийн 30 сурагч хамруулсан. 2022 оны 09 сард доктор Бат-отгоны лекц, зан заншил судлаач лектор С.Дамбийгийн монгол ёс заншлийн тухай лекцэнд ахлах бүлгийн сургачдийг хамруулав. Намрын цэрэг татлагын үеэр эрэгтэй ахлах бүлгийн сурагчдад цэргийн штабын офицер яриа таниулга хийсэн. | 90 |
| 4.5.1.2 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэн нөөцийг бүрдүүлэх | | | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг 2019 онд батлуулсан томилгоот бүрэлдэхүүнийг жил бүр тодотгон өөрчилж байгаа. Нөөцийн судалгааг улиралд хийж нөхн бүрдүүлэх нөөц байхгүй хангалт нөөц хэвийн байна. | 70 |
| 4.5.1.3 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах | | | Багийн дарга нараас судалгаа авсан. 2021 онд санал ирээгүй. Дүйцүүлэх албанд 3 хүн хамрагдаж байна. Сургалт цаг үеийн ажилд дайчлан оролцуулж алба гүйцэтгэсэн цаг, хоног бүртгэж байна. 2022 онд дүйцүүлэн хаах залуучуудыг судлан тодорхойлох, ИТХТэргүүлэгчдийн хурлаар оруулах талаар багийн Засаг дарга нарт чиглэл үүрэг өгсөн 01 сард хамруулах залуучуудыг аймгийн штабт мэдээллийг хүргэнэ. | 90 |
| **ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**<br>5.1 Ногоон хөгжил | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зорилт: 5.1.1 | Зорилго: Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 4 хувиар бууруулна. | Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх ажил сумандорон нутагтаа төдийгүй уул уурхайн нөлөөллийн бүсэд мод, бут, сөөгийг их хэмжээгээр тарьж ургуулах, арчиллага тордолгоог хийж ажиллаж байгаа. | 90 |
| 5.1.1.1 | Утаа багасгах чиглэлээр утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуух, айл өрхийн тоог нэмэгдүүлэх | | | Одоогоор Утаа багасгах чиглэлээр утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуух байгуулсан, айл өрхийн тоог нэмэгдүүлэх ажил хийгдэж байгаа. | 90 |
| 5.1.1.2 | Айл өрхийн сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох иргэд, өрхийн санал санаачлагыг дэмжин ажиллах | | | Айл өрхийн сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох иргэд, өрхийн санал санаачлагыг дэмжин ажиллах ажил хэлэлцэгдэж байгаа. | 70 |
| 5.1.1.3 | Төв зам дагуу үйлчилгээний газар, байгууллага аж ахуйн нэгж, аялал жуулчлал, уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлэх | | | Төв зам дагуу үйлчилгээний газар, байгууллага аж ахуйн нэгж, аялал жуулчлал, уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлэх ажил зам дагуух үйлчилгээний газар, уул уурхайн бусэд эко 00 байгуулах ажил хэлэлцэж байгаа. 2022 онд Говийн зэрэглээ төслийн хүрээнд төв зам дагуу 2 ш жорлон 1ш хогийн цэгийг цайны газар гэрээгээр хүлээлгэн өгч арчилгааг хариуцуулан, Олдохын жандмань дэлгүүр буудлын хамт олон мөн жорлон хогийн цэг тохижуулан ажиллаж байна. ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн том хогийн савыг төв зам дагуу байрлуулан хогийг зөөвөрлөж байна. Сумнаас 11 кмт замын карманд байрлуулсан 2 хогийн савны хогийг Цэцэрлэгийн хамт олон 2 удаа цэвэрлэж хогийг түүсэн. Цаашид төв зам дагуу үйлчилгээний ариун цэврийн байгууламж барих ААНэгжтэй хамтран ажиллана. | 70 |
| 5.1.1.4 | Хог хаягдлын менежментийг сайжруулах журам боловсруулж хэрэгжүүлэх | | | Хог хаягдлын менежментийг сайжруулах журам боловсруулж хэрэгжүүлэх ажил яригдаж байгаа. Төсөв мөнгө дээр хүндрэл үүссэн. 2022 оны 11 сард хийсэн ажил эрхлээгүй идэвхитэй хайгч иргэдийн уулзалт хэлэлцүүлэгээс сумын хог хаягдлыг ангилах цуглуулах ажлыг хариуцан хийх бүлэг байгуулж сумтай хамтран | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллах хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллах болов. Энэ хүрээнд 2019 онд баталсан хог хаягдлын хураамжийг шинэчлэх асуудлыг 12 сард ИТХ-д оруулан хэлэлцүүлж батлуулж тогтоолын төслийг хэм хэмжээний актанд бүртгүүлэх ажил хийгдэж байна. Тогтоолоор хураамжийн хэмжээг цэгцлэн нэмэгдүүлсэн. Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон иргэдийн санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан. | |
| 5.1.1.5 | Сумын хогийн савны тоог нэмэгдүүлэх | | | Сумын хогийн савны тоог нэмэгдүүлэх ажил хийгдсэн. Нийт 12ш хогийн савыг зам дагуу болон гэр хорооллын дунд байршуулсан. Байгууллага бүр аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу хог ангилах сав хийж байршуулсан. | 90 |
| 5.1.1.6 | Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 2 эх үүсвэрт суурилуулах | | | Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 2 эх үүсвэрт суурилуулах ажил яригдаж байгаа. 2022 оны ОНХС-ын 15 сая төгрөгний хөрөнгөөр хийгдэх 2 худагт ус цэвэршүүлэгч төхөөрөмж тавих, худгийн тохижилт, сэлбэг хэрэгсэлээх хангах ажил хийгдэж амжаагүй хойшилж байна. 2020 онд усны иж бүрэн шинжилгээ хийгдэж тайлан хийгдсэн. | 90 |
| 5.1.1.7 | Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | Сумын хэмжээнд Усан сан бүхий газар хамгаалалтын бүс тогтоож, “Улаан жирэм” худгийг хашиж янзалсан, орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан усан сан бүхий газар байхгүй. | 90 |
| 5.1.1.8 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг 100 хувь зохион байгуулах | | | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг 100 хувь зохион байгуулах ажлаар Тугалын бүлээний рашааныг хашиж хамгаалах ажил зохион байгуулагдсан.2022 онд Хөөтийн булгийн эхийг хашиж тохижуулах ажлыг 5 сая төгрөгний өртөгтэй ажлыг иргэний бүлгээр хийсэн. Булгийн хайрханы булгийг хамгаалах тохижуулах ажилд Гачуурт компани хандив өгсөн тохижуулах ажил энэ жилд хийгдэж амжаагүй. | 90 |
| **Зорилт: 5.1.2 Ногоон байгууламжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэх** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5.1.2.1 | Арга хэмжээ: Нийтийн эзэмшлийн газруудад ногоон байгууламжийг бий болгох ажлыг эхлүүлэх | | | Нийтийн эзэмшлийн газруудад ногоон байгууламжийг бий болгох ажилд ИРГЭД, ЗДТГ, ЭМТ, СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ өөрийн эзэмшлийн талбайдаа мод бут сөөгийг тарьж суулгасан. Намрын суулгацын хүрээнд 800 гаруй мод, бут, сөөгийг тарьж суулгасан. "Тэр бум" мод хөдөлгөөний хүрээнд 25 айл, өрх 680, ААН-үүд модны суулгац захиалан авч өөрсдийн хүчээр тарьсан. "Хөх тэрэм" ХХК суманд мод үржүүлгийн газар байгуулан 2800 хайлаас, 300 улиас тарьсан. 16000 мод мөчрөөр, 500,000 мод үрээр тарьсан. Сумын 10 гаруй иргэнийг түр, 1 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. "Голден санрайз" ХХК мод тарьж, 1 иргэнийг байнгын ажлын байраар хангалаа. | 90 |
| **Зорилт: 5.1.3 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 20 га газрын газрын нөхөн сэргээлтийн ажлыг 30 хувьд хүргэнэ.** | | | | | |
| 5.1.3.1 | Арга хэмжээ: Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 6 га-д хийлгэх | | | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 6 га-аас илүү талбайд нөхөн хийлгэж актаар хүлээн авах ажил хийгдсэн. | 90 |
| 5.1.3.2 | Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх ажлыг хийлгэх. | | | "Голден санрайз Энержи" ХХК нөлөөллийн бүсдээ дүйцүүлэх нөхөн сэргээлтийг хийж байгаа. Нөхөн сэргээлтийн хүрээнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд хяналт тавьж ажиллаж байгаа. | 90 |
| 5.1.3.3 | Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулах. | | | Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулах ажил хийгдэж. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэсэн. | 90 |
| **Зорилт: 5.1.4 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх** | | | | | |
| 5.1.4.1 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах | | | Ар цагаан, Ацат хүрэн нийт 50 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах хүсэлтийг дээд шатны байгууллагуудад саналаа хүргүүлсэн. Аймгийн ИТХ-аар оруулж Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлж, Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. 2022 онд орон нутгийн тусгай хэрэгцээнд 20 га газар авахаар ИТХ-аар шийдвэрлэж каюастрын системд бүртгүүлэхээр ажиллаж байна. Хайгуулийн тусгай | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | зөвшөөрлийн хугацаа дууссан газрыг тусгай хэрэгцээнд авахаар судалгаа гарган мэдээлэл авч ажиллаж байна. | |
| **ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**<br>6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил<br>Зорилго: Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулан бүх төлөвлөлттэй уялдуулан сумын төвийн хөгжлийг сайжруулах | | | | | |
| 6.1.1.1 | Арга хэмжээ:<br>Төвлөрсөн цэвэр бохирын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж байгуулах ажлыг судлан хэрэгжүүлэх | | | 2021 онд хийгдэж байгаа сумын ерөнхий төлөвлөгөөнд төвлөрсөн цэвэр бохирын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж байгуулах ажлыг төлөвлөн батлаж дунд хугацаанд төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалтын асуудлыг аймаг УИХ-ын гишүүдтэй хамтран улсын болон гадаадын тусламжийн төсөлд хамруулах ажлыг судлан хөөцөлдөж байгаа. | 70 |
| 6.1.1.2 | Сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлаж мөрдөж ажиллах | | | 2021 онд аймгийн ОНХС-ын 100 сая төгрөгний хөрөнгө батлуулж тендерт шалгарсан ААН-ээр ажлыг гүйцэтгүүлж байна. Гүйцэтгэл 50 хувьтай. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгавар хийгдэх хүсэлт ирсний дагуу хугацаанд нь хийж өгсөн. Бусад суурь судалгааг хийж явуулсан. 2 удаа ирж суурь судалгаа дронтой зураг авалт хийсэн. Шаардалгатай бүх мэдээллээр ханган ажилласан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж байгаа “Сонголт дизайн” ХХКомпаниас 2 удаа ажлын хэсэг ирж зураг төлөвлөгөөг сумын удирдлага иргэдэд танилцуулан ажилласан. 2022 он 11 сард ИТХ-д танилцуулан иргэдтэй уулзаж зураг төлөвлөгөөний эцсийн хэлэлцүүлэг танилцуулгыг хийж дуусгасан. 2023 оны эхээр төлөвлөгөө дуусган ИТХ-аар батлуулах хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 90 |
| 6.1.1.3 | Иргэдийн газар өмчилж авах эрхийн хувийг нэмэгдүүлж, жишиг гудамж төсөл, сумын | | | Энэ онд иргэдийн өмчилж авсан газартаа гэрчилгээжүүлэх ажлыг хийж эрчимтэй нийт 51 өрх | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тохижилт, соёлжилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж эхлүүлэх | | | материалаа бүрдүүлэн авч Улсын бүртгэлээс гэрчилгээжүүлсэн.Шинээр гудам үүсэж байгаа хашааг нэг эгнээнд бариулж хашааг хээлж зосдуулах ажлыг хийсэн. 2022 онд 2 өрх хашаагаа жишиг болохуйц тохижуулсан. Энэ жишгээр сумын ерөнхий төлөвлөгөөнд оруулан хашааны жигдрэлт хийхээр төлөвлөж байна. 2023 онд 100 жилийн ойн хүрээнд хашаагаа жигдлэх тохижуулах ажилд иргэдийн саналаар хөрөнгө мөнгө төсөвлөсөн. | |
| 6.1.1.4 | Сумдад орон сууцны барилга барих хөрөнгө оруулах, төсөл санаачлагыг дэмжин ажиллах | | | Шинээр барьсан барилга байгууламж орон сууц одоохондоо байхгүй. | ХБ |
| 6.1.1.5 | Сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барих зураг төсвийг боловсруулан хөрөнгийн асуудлыг аймгийн удирдлага, Улсын Их Хурлын гишүүдтэй хамтран шийдвэрлэж шинэ байртай болгох. | | | Нутгийн удирдлагын байр шинээр барих ажлын зураг төсөв хийлгэхээр судалж байна.Зураг төсвийн хөрөнгийг 2020 оны ОНХС-ын 15 сая төгрөгөөр баталсан. 2022 онд ЗДТГ-ын өргөтгөл, шингэ барилгын зураг төсвийг Онцгой бест дизайн ХХК-аар шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Хөрөнгийн асуудлыг УИХ-ын гишүүнд тавьж шийдвэрлүүлэхээр хөөцөлдөж байна. | 70 |
| 6.1.1.6 | Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх. | | | Суманд ашиглалтгүй байгаа барилга Сургуулийн 50 хүүхдийн дотуур байр, махны зоорь, ЗДТГазрын нүхэн зоорь зэргийг акталж, аймгийн Орон нутгийн өмчиийн газарт хүргүүлсэн. Дуудлага худалдаа зохион байгуулсан актлах устгах хөрөнгийг устгаж данс бүртгэлээс хассан. Сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу Иргэдийн санал авч ашиглалтгүй барилгыг буулган газрын чөлөөлөхөөр ажиллаж байна. | 70 |
| 6.1.1.7 | Малчдын өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлэх | | | Малчдаас өвөлжөө хаваржааны маргаан энэ хугацаанд нэг өргөдөл гомдол ирсэн уг маргааныг багийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр иргэнд хариуг биечлэн амаар | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хүргэсэн.Өлзийт сумын нутаг дэвсгэрт орсон өвөлжөө хаваржааг тус сумын төлөөлөгчдийн хурлаар оруулсан боловч тус сумын ИТХ-ын дарга шинээр ажлаа авч байгаа тул судалж үзээд дараагийн хурлаар хэлэлцэх хариуг хүргэсэн. Өөр сумдын хилд орсон өвөлжөө хаваржааны бичиг баримтыг гаргуулах ажлыг биечлэн хийж үр дүн гаргах тал дээр анхаарч ажиллана. 2022 онд хөрш Өлзийт сумын Тагт багийн малчдын хуралд газрын даамлын хамт оролцож малчдын тавьсан санал хүсэлтийн дагуу газар бууцны маргааны асуудлыг танилцуулав. Өлзийт сумын ИТХ, Засаг даргад албан тоот илгээж хамтран ажиллах маргаан зөрчлийг арилгах талаар санал тавьсан. | |
| 6.1.1.8 | Сумын ахмадын байрын нөхцөлийг сайжруулан үйл ажиллагааг дэмжих | | | Ахмад настны тухай хуулийн дагуу ахмадын өдөр тэмдэглэх ахмад настны чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх хүрээнд ахмадын хорооноос тавьсан саналуудыг хүлээн авч Засаг даргын нөөцөөс 2 сая төгрөгний хөрөнгө гарган дэмжлэг үзүүлэв. Цаашид байрны асуудлыг иргэдийн санал авсны дагуу ОНХС-ын хөрөнгөөр засаж дэмжихэд туслах, өөрийн хөрөнгөд байрыг бүртгүүлэх шилжүүлэхэд дэмжиж ажиллах шийдвэр гаргуулахад туслахаар болсон | 70 |
| Зорилт : 6.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | | | | | |
| 6.1.2.1 | Арга хэмжээ: ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх | | | 2022 онд шилжих хөрөнгө оруулалт 4 ажилд 54,5 сая, шинээр эхлэх 9 ажилд 224,7 сая, малын тоо толгойн албан татвараар санхүүжих 6 ажилд 85 сая нийт 422,9 сая төгрөгний орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэв. Үнээс төрийн хэмнэлтийн хуулиар 1 төсөл хасагдаж 2 ажил оэд багтахгүй шилжиж бусад ажлууд хийгдсэн байна. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6.1.2.2 | Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron nutag.mn сайтад тухай бүр мэдээлэх | | | Хэрэгжиж буй төсөл арга хэмжээний мэдээллийг цахим системд болон тухай бүр төсөв орон нутаг сайтад байршуулан ажиллаж байна. | 90 |
| 6.1.2.3 | Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдийн саналыг цахимаар авч оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | | | ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдийн саналыг цахимаар болон саналын хуудсаар авч бүх БИНХ-ын Тэргүүлэгчид болон ажлын хэсгээр эрэмблүүлэн цахимд системд бүрэн оруулсан. 2022 онд 2023 оны ОНХС-ын саналыг хууль журманд заасан хугацаанд БИНХ, малчдын чуулганаар болон цахимаар авч саналын сумын ажлын хэсгээр эрэмбэлэн ИТХ-д оруулан хэлэлцүүлэхэд бэлэн болгов. | 90 |

**ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН: АРХИВ БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН М.ГАНТУУЛ**

**ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.СҮХДОРЖ**

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭСЭН ХУВЬ

2021 оны 12 сарын 07 Улаанжирэм

| № | Агуулга | Зорилго | Зорилтын тоо | Зорилтын хэрэгжилт | Арга хэмжээний тоо | Арга хэмжээний хэрэгжилт дундаж хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | 1 | 1 | 86 | 8 | 90 | |
| 2 | ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 7 | 15 | 75,8 | 52 | 81,3 | 1 хугацаа болоогүй заалт байв. |
| 3 | ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | 3 | 6 | 95,5 | 32 | 82,6 | 2 хугацаа болоогүй заалт байв. |
| 4 | ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | 3 | 6 | 69,6 | 43 | 81,6 | |
| 5 | ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 1 | 4 | 88,7 | 13 | 87 | |
| 6 | ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 1 | 2 | 63,7 | 11 | 71 | 1 хугацаа болоогүй заалт байв. |
| | Хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн дундаж | 16 | 34 | 69,4 хувь | 159 | 82,2 хувь | |

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ БОДЛОГЫН ХҮРЭЭГЭЭР АВЧ ҮЗВЭЛ

*2022 оны 12 сарын 07* *Улаанжирэм*

| | Үнэлэх шалгуур , Бодлого хүрээ | НЭГ."КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | Хувь нэгтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь; | 8 | 34 | 22 | 28 | 11 | 4 | 107 |
| 2 | 6.2.2.2. тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь; | 0 | 16 | 5 | 12 | 2 | 6 | 41 |
| 3 | 6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил | 0 | 1 | 3 | 3 | 0 | 0 | 7 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;* | | | | | | | |
| 4 | *6.2.2.4. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | *Хугацаа болоогүй* | | 1 | 2 | 0 | | 1 | 4 |
| 5 | *6.2.2.5. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | *Нийт арга хэмжээний тоо* | 8 | 52 | 32 | 43 | 13 | 11 | 159 |
| | **ДУНДАЖ ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ** | 86 | 80 | 84 | 77 | 87 | 66 | Дундаж хувь 82 |

***ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭЛ***

***2022 оны 12 сарын 07*** ***Улаанжирэм***

| № | Агуулга | Зорилго | Зорилтын тоо | Зорилтын хэрэгжилт | Арга хэмжээний тоо | Арга хэмжээний хэрэгжилт дундаж хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн захиргаа удирдлагын хүрээ | 2 | 4 | 73 | 38 | 90 | |
| 2 | Хууль эрх зүйн хүрээ | 2 | 5 | 79 | 26 | 80 | |
| 3 | ХШҮДАХэлтэс мэдээ тайлан | 1 | 1 | 90 | 1 | 80 | |
| 4 | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлт хүрээ. /Дэд бүтэц, ХАА, МАА, байгаль орчин/ | 4 | 7 | 65 | 61 | 80 | |
| 5 | Нийгмийн бодлогын хүрээ | 8 | 15 | 75 | 70 | 90 | |
| | **Гэрээний хэрэгжилтийн дундаж** | **17** | **32** | **76 хувь** | **196** | **84 хувь** | |

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН: АРХИВ БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН М.ГАНТУУЛ

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.СҮХДОРЖ

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн

хэрэгжилтийг дүгнэсэн тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны 2022 оны хэрэгжилтийг хэлэлцээд  82.2 хувийн хэрэгжилттэй / Хангалттай) гэж дүгнэсүгэй.
2. Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон Хуралд танилцуулах, Төлөөлөгчдийн санал дүгнэлтийг тусган хэрэгжүүлэхийг Засаг дарга /П.Бямбалхагва/-д үүрэг болгосугай.

ДАРГА А.ОТГОНБААТАР

Санаачлагыг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Суманд МАА-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд малчдын санаачлагаар байгуулагдсан Олдох багийн Аривжих, Баянтал, Уул багийн Хулд уул бүлгээс танилцуулсан үйл ажиллагаа, санаачлагыг дэмжсүгэй.
2. Бүлгийн үйл ажиллагааны талаар тавьсан санал, санаачлагыг 2022 оны ажлын төлөвлөгөө, гэрээнд оруулан хөрөнгө, санхүү, зохион байгуулалтын хүрээнд дэмжин ажиллахыг Засаг дарга /П.Бямбалхагва/-д үүрэг болгосугай.

ДАРГА А.ОТГОНБААТАР